




МОНГОЛ ДААТГАЛ

ЖИЛИЙН ТАЙЛАН



2020



 **1800-1990**
ДААТГАЛЫН ЛАВЛАХ



АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгууллага бүрт хүргэсэн дэлхийн жишиг компани байна



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж итгэлтэй ирээдүйг бүтээлцэнэ.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эх орныхоо тайван амгалан, иргэдийнхээ тав тухтай амьдрал, Монгол улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм хэрэглэгч Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

Монголын даатгалын салбарын үүсэл хөгжлийг эхлүүлсэн анхдагч компани "Монгол Даатгал" ХК-ийн хувьд өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээ бүхий 700 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон, цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож, судлан, байнгын сайжруулалтыг хийж, 2019 оны байдлаар бидэнд итгэл хүлээлгэсэн даатгуулагчдын тоо 255 мянгад хүрч, жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна. Бид хөгжлөөрөө ямагт анхдагч, тэргүүлэгч байгааг хэлэхэд таатай байна. Түүнчлэн бид дэлхийд нэр хүндтэй, өндөр зэрэглэлтэй, тэргүүлэгч давхар даатгалын компаниудад эрсдэлээ шилжүүлснээр харилцагчиддаа давхар даатгагдсан хамгийн өндөр багцыг санал болгох боломжийг бүрдүүллээ.

Харилцагчидтайгаа хамтдаа хөгжүүлж буй бидний бизнес өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа нь иргэд, байгууллагуудын даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ухамсар нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч хүмүүний итгэлтэй ирээдүй, амар тайван амьдралын төлөө бидний итгэл үнэмшил цуцашгүй байж, даатгалын үйлчилгээг хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд тэмүүлсээр байх болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧООН



Давхар ёндоотой даатгал

Тээврийн хэрэгслийн даатгал "Давхар ёндоотой даатгал" аяныг зохион байгуулж хэрэгжүүлж байна.




Талын 5 эрдэнэ

2020 онд орон нутгийн голлох бүтээгдэхүүнүүд Малын индексжүүлсэн даатгал талын 5 эрдэнэ урамшуулалт аяныг зохион байгуулж, борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 41 хувийн өсөлт үзүүлсэн



Бэлэгтэй даатгал

"Уралдаанч хүүхдийн бэлэгтэй даатгал" урамшуулалт аяныг зохион байгуулж өмнөх оны мөн үеэс 33 хувийн өсөлт үзүүлсэн



Чатбот

Онлайн даатгал MANYCHAT bot, нэвтрүүлэн харилцагч өөрт хэрэгтэй даатгалын үйлчилгээ болон зөвлөгөө мэдээллийг цахимаар авах боломжтой болсон



HubSpot

HUBSPOT CRM дээр сөжим хуваарилан байгууллагын даатгалын борлуулалтыг дэмжиж ажилласна нийт 100.0 саяаас дээш үнэлгээтэй тээврийн хэрэгслийн даатгалд 170 градус бичдэг НР брэндийн камер бэлгэнд өгч байна.




Бяцхан Монгол Зүрх

Нийгмийн хариуцлагын хүрээнд Эх нялхас эрүүл мэндийн төвтэй хамтран зүрхний төрөлхийн гажигтай төрсөн хүүхдүүдийн мэс заслын зардлыг дааж бидний ирээдүй болсон энхрий бяцхан хүүхдүүдэд амьдрал бэлэглэх "Бяцхан Монгол Зүрх" сайн үйлсийн аяныг санаачлан хэрэгжүүлэв.



Яараад Яахав дээ 2

Цагдаагийн ерөнхий газартай хамтран замын хөдөлгөөнд оролцогч жолооч, зорчигч нарын эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хөдөлгөөний соёл, зөв дадал, хандлага төлөвшүүлэх замаар "Яараад Яахав дээ" аяныг улсын хэмжээнд 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулсан.



Сошиал медиа

Social media албан ёсны пейж хуудас лайкын тоо 36к-40к д хүрсэн нийт 160 контент үйлдэрлэн давтагсан тоогоор 14м сая удаа хүргэсэн.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖИЛ 2020/21

“Монгол Даатгал” ХК-ийн Бизнес хөгжлийн газарт харьяалагдах Бүтээгдэхүүн хөгжил хариуцсан нэгж нь 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төлөвлөгөөт бус зайлшгүй үүрэг даалгаврын хүрээнд нийт 4 төрлийн шинэ бүтээгдэхүүнийг боловсруулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохих зөвшөөрлийг авч бүртгэлжүүлсэн ба нийт 8 төрлийн бүтээгдэхүүнийг зайлшгүй шаардлагуудад нийцүүлэн засварлан сайжруулж өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн тус тус зах зээлд нэвтрүүлээд байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран Дотоодын эрүүл мэнд, Олон улсын эрүүл мэнд болон Амгалан хорт хавдрын даатгалын бүтээгдэхүүнийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэн, холбогдох заавар зөвлөгөөг өгч ажилласан ба гэрээ болон бүтээгдэхүүний мониторинг хийх, нэмэлт шинжилгээ судалгаа хийх, шинэ хамтын ажиллагааг дэмжих зэрэг бусад төрөлд хамаарах ажлуудыг зохих хугацаанд хийж гүйцэтгэсэн байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ БА САЙЖРУУЛАЛТ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан төлөвлөгөөний дагуу 2020 онд дараах 4 бүтээгдэхүүнүүдийг шинээр боловсруулан зах зээлд нэвтрүүлээд байна.



Нийтийн автотээврээр зорчигчийн гэнэтийн ослын даатгал

“Авто Тээврийн Үндэсний Төв”-тэй 2016 оноос хойш хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос зорчигчид зориулсан гэнэтийн ослын даатгал гэсэн нэртэйгээр тусдаа бүтээгдэхүүн болгон бүртгүүлэх шаардлага тавьсаны дагуу зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг үргэлжлүүлэх зорилгоор уг бүтээгдэхүүнийг боловсруулсан.

ЭРСДЭЛ

- Зам тээврийн осол, Байгалийн эрсдэлийн улмаас болон Тээврийн хэрэгсэл түр саатах үед зорчигч нас барах, хөдөлмөрийн чадвараа алдах
- Байгалийн эрсдэлийн улмаас зорчигчдыг түр хугацаагаар суурин газарт саатуулах

ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- Үнэлгээ- 5, 10, 15 сая төгрөг
- Хураамж- Үнэлгээ, зорчих тасалбараас хамаарч 100 - 6000 төгрөг

НӨХӨН ТӨЛБӨР

- Хөдөлмөрийн чадвар алдсан хугацаа болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувиас хамааран 5%-100% хүртэл нөхөн төлнө.



Хүүхэд хамгааллын даатгал

Нийгмийн хариуцлагын хүрээнд мөн “Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар”-тай хамтын ажиллагааг өргөжүүлэх, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх хөшүүрэг болгох зорилгоор эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд хамгааллын даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулсан.

ЭРСДЭЛ

- Бүх төрлийн гэнэтийн осол
- Хүчирхийлэлд өртөх
- Хүүхэд алга болох

ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- Үнэлгээ 5 сая – 45 000 төгрөг
- Үнэлгээ 10 сая- 90 000 төгрөг

НӨХӨН ТӨЛБӨР

- Эрх бүхий мэргэжлийн байгууллагуудад зардлын баримтад үндэслэн заагдсан лимит хүртэл нөхөн төлнө.



Автотээврийн хэрэгслийн даатгал (эрсдэлийн сонголтот)

Дараах зорилгын хүрээнд шинэ инноваци бүхий автотээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулан гаргасан.

- ✓ Даатгуулагч зөвхөн өөрт тохирсон эрсдэлийг сонгон даатгуулах боломжийг олгох
- ✓ Шударга зарчимд нийцсэн хураамжийн тооцооллын системийг нэвтрүүлэх
- ✓ Багц эрсдэлээр даатгадаг бүтээгдэхүүний хуучин моделийг өөрчлөх
- ✓ Зах зээл уг шинэ дизайн бүхий бүтээгдэхүүнд бэлэн эсэхийг тандах

ЭРСДЭЛ

- Заавал сонгох эрсдэл
- Хөдөлгөөний үе
- Байгаль
- Өөрийн хүсэлтээр сонгох эрсдэл
- Хөдөлгөөний бус үе
- Гал
- Хулгай дээрэм
- Жолоочийн гэнэтийн осол
- Зорчигчийн гэнэтийн осол

ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- Даатгалын хураамж тээврийн хэрэгсэл болон жолоочийн дараах мэдээллээс хамааран өөр өөр байна.
- Жолоочийн тоо
- Жолооны туршлага
- Нөхөн төлбөр авч байсан тоо
- Осол гаргаж байгаагүй тоо
- Моторын багтаамж
- ТХ-ийн ангилал
- Хувийн автозогсоол байгаа эсэх
- Дохиоллын системтэй эсэх

НӨХӨН ТӨЛБӨР

- Даатгуулагчийн сонгосон эрсдэлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлнө.



Дотоод аяллын даатгал

Covid 19 гарч гадагшаа чиглэх урсгал багасан дотоодын аялал хөгжиж аялагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор шинэ зах зээлийн эрэлт үүссэн тул дотоодод үйлчлэх аяллын даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулсан.

ЭРСДЭЛ

- Бүх төрлийн гэнэтийн осол

ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- Нас, аяллын хугацаанаас хамааран ялгаатай тогтоно

НӨХӨН ТӨЛБӨР


- Хөдөлмөрийн чадвараа алдсан хувиас хамааран үнэлгээний 50-100 хувь хүртэл нөхөн төлнө.
- Эмчилгээний зардлын баримтад үндэслэн үнэлгээний 50 хувь хүртэл нөхөн төлнө.
- Эмнэлэг хүртэл зөөн тээвэрлэх зардлыг үнэлгээний 20 хувь хүртэл нөхөн төлнө.



ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГА & ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БАГЦ ДААТГАЛ

Өндөр үнэлгээтэй машинуудад зориулсан Тээврийн хэрэгсэл, Албан журмын жолоочийн хариуцлага, Сайн дурын жолоочийн хариуцлагын 3 даатгалыг бүтээгдэхүүнийг багтаасан цогц бүтээгдэхүүнийг боловсруулсан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ 2020/21



Росгосстрах компанитай хамтын ажиллагаа:

Хорт хавдрын эрсдлийн бүтээгдэхүүний нөхцөл журмыг хэлэлцэн эрсдлийг 100% РГС компани руу гарган хамтын ажиллагааны гэрээг үзэглэв.

Энэ хүрээнд үйлчилгээ үзүүлэгч байгууллага НМС компанитай мөн хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллав.

ЭМД-ын нөхцөл, хураамжаар өрсөлдөхүйц бүтээгдэхүүн 33-д гаргах үүднээс шинэ ДД-гч судласны дүнд Hannover Re компанитай хамтран ажиллахаар болж 20/80 квота шейр трийтиг эцэслэв. Үүний дүнд, Монгол Улсад үйлчлэх бага хамгаалалттай, бага хураамжтай бүтээгдэхүүн болон олон улсад үйлчлэх даатгалын бүтээгдэхүүнийг нэг давхар даатгагчид даатгуулан ажиллахаар болов

Дотоодын эрүүл мэндийн даатгал:

Гэр бүл: Гэр бүлийн хөнгөлөлттэй хураамж гэж байдаг тул 4 болон түүнээс дээш ам бүл хөнгөлөлттэй хураамжаар даатгуулах боломжтой. Ерөнхийдөө 40-оос дээш насны эхнэр, нөхөр 18 хүртэл насны хүүхдүүдтэйгээ даатгуулсан тохиолдолд энэ хөнгөлөлттэй хураамжинд хамрагддаг байгаа.

Хувь хүн буюу иргэн ганцаараа, эсвэл ээж, аав, эмээ, өвөө-өө даатгуулж болно.

Зарим байгууллагууд гадаад захирал болон гадаад зөвлөхдөө заавал ЭМ-ийн

«Амгалан» Хорт хавдар, хүнд өвчний эрсдэлийн даатгал

Даатгалын бүтээгдэхүүний эхний жилийн гэрээний хугацаанд хүлээлгийн хугацаа зааж өгсөн байгаа нь хорт хавдар, хүнд өвчний эрсдэлийн даатгалын бүтээгдэхүүний хувьд олон улсын мөрддөг стандарт бөгөөд гэрээний эхний жилийн хүлээлгийн хугацаа дуусч дараа жилийн сунгалтын үед хүлээлгийн хугацаа байхгүй болдог. Ингэснээр даатгуулагчийн хувьд тусламж үйлчилгээг бүрэн авах эрх нээгдэж байгаа юм.

Бүтээгдэхүүний давхар даатгагч "Росгосстрах" компани нь ОХУ-ын анхны даатгалын компани бөгөөд 1921 онд үүсгэн байгуулагдсан. Одоо тус компани нь "Открытие" группд хамаардаг ба зах зээлийн тэргүүлэгч юм. Үндэсний үзүүлэлтийг тодорхойлогч Expert RA агентлагийн "ruAA-3", олон улсын Standard&Poor's агентлагаас BB- үзүүлэлтээр урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлын рейтинг олгосон байгаа нь үндэсний хөрөнгө оруулалттай даатгалын байгууллагуудын дунд хамгийн дээд хэмжээний үзүүлэлт юм.



Бусад

Дотоод дахь хамтын ажиллагааны гэрээтэй 6 эмнэлгийн гэрээг сунгаж, 5 шинэ эмнэлэгтэй гэрээ байгуулав. Мөн эмнэлгүүдээр очиж зөвлөмж, сургалт зохион байгуулав.


Эмнэлгийн нэр	Сунгалт/шинэ
УБ Сонгдо	Сунгалт
УБ Мед	Сунгалт
Интермед	Сунгалт
Мэдипас/Эрдэнэт хот/	Сунгалт
Сөүл Сонгдо	Сунгалт
Мөнгөн Гүүр	Шинэ
Цэгц Дэнт	Шинэ
Болор Мэлмий	Шинэ
Гялс	Шинэ
Сан Медикал	Шинэ
Гранд Мед	Сунгалт
Асралт Мед	Гэрээ бэлэн. Тэдний талаас харахан зурж баталгаажаагүй байна.

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ХЭЛТЭС 2020/21

2020/1-р улирал / Борлуултанд чиглэсэн ажлууд

Агентын веб:

Борлуулалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор агент, зуучлагчид зориулсан веб болон чатбот-г хөгжүүлж үүгээр дамжуулан дараах даатгалыг хийх боломжтой болов.



МАБ, техник сайжруулалт:

- Байгууллагын мэдээллийн системийн найдвартай байдлыг хангах зорилгоор нөөц төвийг iTools компани дээр байгуулав.
- Орон нутгийн сүлжээг сайжруулав: Шинэ үеийн хөдөлгөөнт интернетийг орон нутагт нэвтрүүлснээр найдвартай байдал нэмэгдэж зардал бууран шаардлагатай үедээ хаанаас ч төв програмтай холбогдон борлуулалт хийх боломжтой болов.
- Нөөц интернет: Sightcall болон CallPro (интернет сүлжээнд суурилсан холбоо) үйлчилгээ нь интернет сүлжээнд суурилсан бөгөөд интернет тасрахад эдгээр үйлчилгээ тасалдах эрсдэлтэй байсан учир байгууллагын нэг гарцтай интернет сүлжээг хоёр болгож мэдээллийн системийн найдвартай байдлыг нэмэгдүүлэв.

Шинэ техник технологийн нэвтрүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийв.


- **Sightcall систем нэвтрүүлэх:** Дэвшилтэд техник технологид суурилсан Sightcall системийг өөрийн хөгжүүлсэн гар утасны програм болон үндсэн систем болох 1С програмтай интеграци хийж, энэхүү үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болгов. Энэхүү технологийг ашигласанаар даатгал тохиолдолын баталгаажуулалт болон борлуулалтыг алсын зайнаас хийх зэрэг бусад олон боломжуудыг бий болгов.
- **CRM систем нэвтрүүлэх:** Харилцагчтай харьцсан харилцааны түүхийг төрөл бүрээр бүртгэх, уулзалтыг товлох, маркетинг хийх боломжтой HUBSPOT CRM системийг нэвтрүүлэв. 1С-с харилцагч болон хэлцлийн талаарх мэдээллийг хөрвүүлж ManyChat бот-той интеграци хийв. Ингэснээр манай байгууллага уруу хандсан бүхий л сэтгэмжийг бүртгэн авч борлуулалтыг нэмэгдүүлэх боломжтой болов.

ДАВХАР ДААТГАЛ 2020/21

Давхар даатгалын үйл ажиллагаа тогтвортой явагдаж өмнөх факультатив давхар даатгалын гэрээ хэлцэлүүдийг сунгаж, багцын давхар даатгалын хүчин чадлаас давсан шинээр байгуулагдсан даатгалын гэрээ тус бүрийн эрсдэлийг давхар даатгалын зах зээлд амжилттай байршуулж ажиллалаа.

ДАВХАР ДААТГАЛЫН ТҮНШҮҮД


2020 онд Монгол Даатгал ХК нь шинэ болон хуучин давхар даатгагчид, брокерийн пүүсүүдтэй хамтарч ажиллаж ажиллалаа. Мөн Үндэсний давхар даатгал ХК хамтын ажиллагаагаа



ХУВЬЦААНЫ АРИЛЖАА 2020

2020-01.31 - 2020-12.31

Хаалтын ханш




Арилжаалагдсан ширхэг




Хаалтын ханш: 1,820.00
 Нийт хувьцааны тоо ширэг: 64,132,341

САНХҮҮГИЙН ТАЙЛАН 2020

ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ



2020



ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

НИЙТ ХУРААМЖ

2020 /Төг/

23,097,936,869

НИЙТ ХӨРӨНГӨ

2020 /Төг/

34,905,574,157

НӨХӨН ТӨЛБӨР

2020 /Төг/

7,654,374,406

ЦЭВЭР ХУРААМЖ

2020 /Төг/

16,364,216,745

НӨӨЦ САН

2020 /Төг/

18,423,298,484

ОРЛОГЫН ТАЙЛАН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД:	2020
	<i>/төгрөг/</i>
НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО	23,097,936,868.81
ЦЭВЭР ХУРААМЖ	16,364,216,747.35
НӨХӨН ТӨЛБӨР	7,654,374,406.71
ДАВХАР ДААТГАЛ	6,254,421,467.04
АШИГТАЙ АЖИЛЛАГАА	319,774,403.40
БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	
НИЙТ ХӨРӨНГӨ	34,905,574,157
ЭЗДИЙН ӨМЧ	13,962,950,150
НӨӨЦ САН	18,423,298,484.56
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	23,167,993,018.36
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	11,737,581,138.79

ОРЛОГЫН ТАЙЛАН	2020
	<i>/төгрөг/</i>
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	23,097,936,869
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ	433,922,784
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ	319,774,403

НӨХӨН ТӨЛБӨР

төг

	2020	2019
Нөхөн төлбөр	7,654,374,407	17,868,071,349
Даатгалын системд эзлэх НТ %	13%	28
ДС нөхөн төлбөрийн дүн	59,273,460,179	63,901,840,723
НТ авсан даатгуулагчийн тоо	9,979	14,633

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

	ROE	ROA	ROI	Хохирлын харьцаа	Зардлын харьцаа	Хос харьцаа
2019	0.8%	0.2%	13.9%	46%	71%	117%
2020	2.3%	1.0%	11.2%	45%	68%	113%



Даатгалын лавлах: 1800-1990
Буухиа даатгал: 7010-1990



Цахим хаяг:

Цахим хуудас: www.mongoldaatgal.mn
Цахим хаяг: insurance@mongoldaatgal.mn
Facebook: [/mongoldaatgal](https://www.facebook.com/mongoldaatgal)
Twitter: [/mongoldaatgal](https://twitter.com/mongoldaatgal)



Төв байр:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо,
Үндсэн хуулийн гудамж 32



CHATBOT QR кодыг
уншуулан нэгдээрэй